



**Л.АЛТАНСҮХ**  
Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн эрхлэгч,

дэд хурандаа, хууль зүйн магистр

### ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Төрийн эрүүгийн бодлогын хэрэгжилтийн нэг гол илрэл, голлох байр суурь эзлэгч ойлголт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх түүн дотроо ял эдлүүлэх ажиллагаа, түүний хэрэгжилтийн тухай асуудал юм. Эрүүгийн бодлого, ялын бодлогыг судлах хүрээнд ял эдлүүлэх ажиллагааны бодлогын өнөөгийн байдал, хэрэгжилт, тулгамдсан асуудал, хөгжлийн чиг хандлагын талаар авч үзэх нь эрүүгийн бодлогыг цогц байдлаар тодорхойлох, түүнд дүн шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд ялын төрөл тус бүрийн хэрэгжилт, түүнд тулгамдаж буй асуудлыг авч үзье.

#### *1. Хорих ял эдлүүлэх ажиллагаа:*

Хорих ял нь төрийн цээрлэл, ялтанд үзүүлэх албадлагын онцгой арга хэмжээ, хүмүүжүүлэх, нийгэм, ард иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь гол хэрэгслийн нэг гэдэгтэй хүн болгон санал нийлэх бизээ. Сүүлийн жилүүдэд шүүхээс оногдуулж буй нийт ялын 60-70 орчим энэ төрлийн ял эзэлж буй бөгөөд өнөөгийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд төвлөрсөн хорих анги 25, /үүнээс гяндан 1, онцгой дэглэмтэй хорих анги 1, чанга дэглэмтэй хорих анги 11, жирийн дэглэмтэй 11 хорих анги/ шүүхээс

оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 онд батлагдан гарч мөрдөгдөж эхэлснээс хойш 2002 оноос 2012 оны эцсийн байдлаар хорих ялтай-66228 ялтныг холбогдох хууль журам, тогтоосон цагийн хуваарь, зохих дэглэмийн дагуу хорих ялыг албадан эдлүүлж иргэн, нийгэмд учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан байна.<sup>5</sup>

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг хангах, ялын зорилгын биелэлтийг хангах асуудал чухлаар тавигдаж буй өнөө үед хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн арга хэмжээ болох нийгэмшүүлэх, хөдөлмөрлүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, ялтны зүгээс гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажиллагааны хэрэгжилт хэрхэн явагдаж буй талаархи зарим нэгэн тоо баримтыг авч үзье. Тухайлбал:

а/ БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 3-р сарын 24-ний өдрийн 50 дугаар зарлигаар батлагдсан БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулиар хорих ял эдлүүлэх байгууллагын төрлийг а/ гяндан, б/ засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, в/ хүмүүжил-хөдөлмөрийн колони гэж тогтоон, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонийг дотор нь жирийн, чанга, онцгой дэглэмтэй байхаар заасан төдийгүй тус бүрийн нөхцөлийг хуульчилсан нь өнөөг хүртэл хэрэгжиж байна.

Ийнхүү 1966 онд буюу 45 жилийн өмнө хуульчлагдсан хорих байгууллагын төрөл, дэглэмийн ялгаа нь дараа, дараагийн хуулиудад /1981,1993,1996, 2002 оны/ эх сурвалж болон батлагдсан юм. Энэ байдал нь нэг талаар олон жил тогтвортой үйлчилсэн гэж үзэх сайн талтай ч нөгөө талаар хорих ялын

<sup>5</sup> Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн судалгаа 2012 он



зорилгыг хангах буюу хорих ял эдлүүлэх явцад ялтныг нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх, суллагдахад бэлтгэх зэрэг асуудлууд бүрэн зохицуулагдаагүй, нийгмийн хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцэхгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Өнөөгийн хүчин төгөлдөр даган мөрдөгдөж буй Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлэхээр зохицуулсан байдаг.

Хорих байгууллага нь ялтны аюулгүй байдлыг ханган, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтнаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр дадлага олгох, гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгаж хохирогчид шилжүүлэх зэрэг хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг дээрхи төрөл, дэглэмийн хүрээнд хэрэгжүүлж ирлээ.

Одоогийн мөрдөгдөж буй дэглэмүүдийн хоорондын ялгааг авч үзвэл ялтны эргэлт уулзалтын давтамж, захидал харилцаа, илгээмжийн тоон хязгаарлалт, ажлын цаг, хоолны илчлэгийн зөрүү, хамгаалалтын бүс, түүнд ашиглагдаж буй техник хэрэгсэл зэрэг үзүүлэлтээр жирийн дэглэмээс онцгой дэглэм рүү нөхцөлийг хүндрүүлэх шинж чанартайгаар хууль тогтоомжоор зохицуулан тодорхойлсон байна.

Эндээс үзвэл өнөөгийн хорих ял эдлүүлэх дэглэмийн ялгаа нь ахуйн болон зарим шаардлагагүй хязгаарлалтыг хэлбэрийн төдий агуулж байгаа нь хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх цаг үеийн шаардлагыг хангаж чадахгүйд хүрч байна.

б/Ялтныг нийгэмшүүлэх асуудал нь хорих газарт ял эдлээд суллагдсан этгээд дахин гэмт хэрэг үйлдэхгүй, иргэнцсэн бие хүн болон төлөвшин, нийгмийн амьдралд зөв амьдрахад

туслахад чиглэсэн сэтгэл зүй, нийгмийн ажил, эрх зүй, менежментийн цогц арга хэмжээ бөгөөд 2012 оны байдлаар нийт ял эдлэж буй 6000 гаруй хүний 50 орчим хувь урьд гэмт хэрэг үйлдэн, ял эдлэж байсан этгээдүүд байгаа нь нийгмийн ажлын үр нөлөө муутайг харуулж байна. Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтныг нийгэмшүүлэх тухай асуудал зохицуулагдаагүй, зөвхөн Хорих ангийн нийгмийн ажлын зааврын хүрээнд явагдаж буй нь энэхүү цогц ажиллагааг салбарын хууль тогтоомжуудаар зохицуулах зайлшгүй шаардлага байгааг илтгэн харуулж байгаа юм. Учир нь ялтныг нийгэмшүүлэх асуудал зөвхөн хорих байгууллагын гүйцэтгэх үүргээр хязгаарлагдахгүй бөгөөд төрийн захиргаа, орон нутгийн байгууллага, хууль сахиулах байгууллага, олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоо чухал юм.

б/Ялтныг хөдөлмөрлүүлэн, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр 2012 оны эцсийн байдлаар төлбөртэй нийт 2834 ялтан 91.237.922.2 мянган төгрөгний төлбөр төлөхөөс 490 ялтан 4.425.166.8 мянган төгрөгийн төлбөр төлөн, 2344 ялтны 86.812.755.4 мянган төгрөгний төлбөр төлөгдөөгүй байна.

Иймээс ялтныг ажлын байраар хангах асуудлыг тодорхой үе шаттайгаар шинэ шатанд гарган, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, хорих байгууллагын дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

## **2. Торгох ял эдлүүлэх ажиллагаа:**

Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг зөвхөн 2013 оны эхний улирлын байдлаар авч үзвэл биелүүлвэл зохих 140 гүйцэтгэх хуудасны 832.7 сая төгрөгнөөс 81 гүйцэтгэх хуудас



буюу 61% буюу 610 сая төгрөгний шийдвэрийг гүйцэтгэсэн байна.

Торгох ялыг шүүхээс төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаажих доод түвшингөөс доогуур орлоготой, оршин суух хаяггүй хүнд оногдуулдаг нь уг ялын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй бөгөөд түүнчлэн ялтан хуулийн алдаатай хийдлийг ашиглан график гарган, бага хэмжээгээр төлбөрөө төлөн гүйцэтгэлийг удаашруулан ял завших оролдлого хийдэг байна.

### **3. Албадан ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаа:**

Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг зөвхөн 2013 оны эхний улирлын байдлаар авч үзвэл биелүүлвэл зохих 168 гүйцэтгэх хуудасны 46800 цагийн албадан ажил хийлгэхээс бодитой биелүүлсэн 36934 цаг буюу 79%-ийг гүйцэтгэсэн байна.

Өнөөгийн байдлаар албадан ажил хийлгэх ялыг аймаг, орон нутгийн тохижилт, үйлчилгээний компаниудад нийгэмд тустай ажил хийлгэж байна. Бодит байдал дээр тухайн албан газрын ажлын байраар хангах, хяналт тавих тал дээр идэвхи санаачилга муу байна. Шүүхээс оногдуулсан ялыг хаана, ямар хөдөлмөр эрхлүүлэх нь тодорхой бус байгаагаас гудамж цэвэрлэх, мод услах, цонх угаах, хаалга онгойлгох зэргээс хэтрэхгүй байгаа нь уг ялын зорилгын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

### **4. Эд хөрөнгө хураах ял эдлүүлэх ажиллагаа:**

Эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг зөвхөн 2013 оны эхний улирлын байдлаар авч үзвэл биелүүлвэл зохих 283 гүйцэтгэх хуудасны 75.6 сая төгрөгнөөс, бодитой биелүүлсэн 169 гүйцэтгэх хуудасны 45.5 сая төгрөг буюу 60%-ийг гүйцэтгэсэн байна.

Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулсан шийтгэх тогтоолдоо тухайн эд хөрөнгийг нэг бүрчлэн тусгах эрх зүйн зохицуулалт бий ч амьдралд “хэдэн төгрөгний эд хөрөнгө хураах” талаар заасан нь уг ял торгох ялын ялгааг арилгаж байна.

### **5. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял эдлүүлэх ажиллагаа:**

Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг зөвхөн 2013 оны эхний улирлын байдлаар авч үзвэл биелүүлвэл зохих 651 гүйцэтгэх хуудаснаас бодитой биелүүлсэн 88 гүйцэтгэх хуудас буюу 14%-ийг биелүүлсэн байна.

Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих боломж муу байна. Учир нь шүүхээс шийдвэрээ ирүүлдэггүй байдал байсаар байна. Шүүхээс гаргаж буй шийдвэрийн 90 орчим хувийг жолоодох эрхийг хасах ял байдаг нь тухайн ялтны тээврийн хэрэгсэл жолоодож буй эсэхэд нь шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих боломжгүй байна.<sup>6</sup>

### **6. Баривчлах ял эдлүүлэх ажиллагаа:**

2002 оны Эрүүгийн хуулиар баривчлах ялын шинэ төрөл бий болсноор улсын хэмжээнд баривчлах ял эдлүүлэх анги 1, 13 баривчлах ял эдлүүлэх байр 2002 оноос 2012 оны жилийн эцсийн байдлаар 1869 ялтанд оногдуулсан баривчлах ялыг эдлүүлсэн байна.

Баривчлах ялын онцлог нь ялтныг нийгмээс тусгаарлан ганцаарчлан хориход

<sup>6</sup> Шийдвэр гүйцэтгэгчдийн нэгдсэн зөвлөгөөнд тависан Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрын дарга Б.Нямгомбын илтгэлээс



оршдог бөгөөд өнөөгийн байдлаар байрны хүртээмжээс шалтгаалан 4-6-гаар хорих асуудал байна, түүнчлэн баривчлах ял эдлүүлэх байрны нөхцөл журам нь жирийн дэглэмтэй адил байна гэж хуульчилсан нь хорих ял эдлүүлэх ажиллагаатай адил нөхцөл журам, эргэлт уулзалттай байгаа нь уг ялын хорих ялаас ялгаатай байдал алдагдаж байна.

### **7.Цазаар авах ял эдлүүлэх ажиллагаа:**

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль тогтоомжуудаар ялын дээд хэмжээ буюу цазаар авах ялыг хэрэглэх тухай асуудал зохицуулагдсан байдаг.Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны 6 дугаар сараас цаашид уг ялыг хэрэглэхгүй байх талаар мэдэгдэл хийснээр УИХ-аас 2012 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пактын цазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II дугаар протоколд нэгдэн орох тухай хууль”-ийг баталсан нь Монгол Улс цазаар авах ялыг халахтай холбоотой шат дараалсан арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалт бий болсон юм.

Өнөөгийн байдлаар 1994 оноос хойш цазаар авах ялаар шийтгүүлсэн 34 ялтны амийг Ерөнхийлөгчийн зарлигаар уучлан 30 жилийн гянданд хорих ялаар сольж ял эдлүүлж байна.<sup>7</sup>

Эрх зүйн шинэтгэлийн өнөө үед ял эдлүүлэх ажиллагааг шинэ шатанд гаргах, ялын бодлогыг шинэчлэх хүрээнд доорхи саналыг дэвшүүлж байна.Үүнд:

1.Дэлхийн ихэнхи улс орнуудад хорих ялаас татгалзан, альтернатив буюу бусад төрлийн ялыг түлхүү оногдуулахад анхаарч байгаа өнөө үед шинэчлэгдэн боловсруулагдаж буй Гэмт хэргийн тухай хуульд хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оруулж өгөх

2.Монгол Улсын хорих ял, бусад төрлийн ялыг эдлүүлэх ажиллагааны үзэл баримтлал нь тодорхой бус байгааг нэг мөр болгон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодлого, үзэл баримтлалыг батлан хэрэгжүүлэх

3.Ял эдлүүлэх ажиллагааг ялын зорилгыг хангахад бүрэн чиглүүлэхэд эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэгч байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, менежментийг сайжруулах гэсэн саналыг дэвшүүлж байна.

<sup>7</sup> ШШГЕГ-ын харьяа Хорих 405 дугаар ангийн танилцуулга 2012 он